

АВЛИГЫН ЭСРЭГ НИЙСЛЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Нийслэлийн Дотоод аудитын алба

1. “Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр” дэх заалт:

Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэлийн хэмнэлт, зарцуулалт дахь хөндлөнгийн хяналт, оролцоог нэмэгдүүлж, **дотоод аудитын** хяналтыг боловсронгуй болгох;

2. Нийслэлийн хэмжээнд 2015, 2016 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан заалт:

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод аудитын хяналтын тогтолцоог сайжруулах, илэрсэн зөрчилд хариуцлага тооцох, дахин гаргахгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах

Тус байгууллага нь үндсэн үйл ажиллагаа болох дотоод аудитын үйл ажиллагаандаа дараахь хууль, эрх зүйн актуудыг мөрдөн ажилладаг. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан Дотоод аудитын дүрэм,
- Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандарт,
- Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар баталсан Санхүүгийн хяналт шалгалтын стандарт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад дотоод аудит хийхдээ дараахь хууль, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ажилладаг. Үүнд:

- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Төрийн албаны тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Захиргааны ерөнхий хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль,
- Нийгмийн даатгалын тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,
- Авлигын эсрэг хууль,
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай,
- Архивын тухай хууль,
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай,
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай,
- Эдгээр хуулиудыг мөрдөхтэй холбогдон гарсан бусад эрх зүйн актууд

2015 оны хэрэгжилт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 42 байгууллагад хийсэн аудитын ажлын хүрээнд 391 зөвлөмж хүргүүлж, нийт 30,099.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 27,165.8 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, 2,905.3 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулах, 28.3 сая төгрөгийн зөрчлийг акт тогтоож, төсөвт буцаан төвлөрүүлэхээр холбогдох байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад сар бүр хийсэн шилэн дансны хяналтын мэдээллийг нийслэл, дүүргээр нь нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд 2015 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр, Нийслэлийн Дотоод аудитын хорооны хуралд 2015 оны 06 дугаар сарын 08-ны өдөр тус тус танилцуулсан. Тус хурлын тэмдэглэлийг үндэслэн НЗД-ийн захирамжаар мэдээллээ оруулаагүй 2 байгууллагын захиралд сануулах сахилгын арга хэмжээ авсан.

Мөн 2015 оны эхний хагас жилийн үзлэгийн дүнг нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 8 дугаар сарын 27-ны өдрийн хуралд танилцуулан тус хурлын тэмдэглэлийг үндэслэн НЗД-ын захирамжаар 18 байгууллагын удирдлагад сануулах сахилгын арга хэмжээ авсан.

2016 оны хэрэгжилт:

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 42 байгууллагад хийсэн аудитын ажлын хүрээнд 263 зөвлөмж хүргүүлж, нийт 11,190.3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 10,356.2 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, 817.1 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулах, 17.0 сая төгрөгийн зөрчлийг акт тогтоож, төсөвт буцаан төвлөрүүлэхээр холбогдох байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан.

Дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2016 оны эцсийн байдлаар өгсөн нийт 263 зөвлөмжөөс хугацаандаа хэрэгжсэн 181, хугацаа болоогүй 71, хугацаандаа хэрэгжээгүй 11 зөвлөмж байна. Мөн 4,495.7 мянган төгрөгийн акт төлөгдөөгүй байна.

Нийслэлийн харьяа төсөвт 44, ОНӨААТҮГ-23 нийт 66 байгууллагын Шилэн дансны тухай хууль, журмын 2016 оны 1-11 сарын хэрэгжилтэнд сар бүр хяналт тавьж ажилласан. Шилэн дансны 2015 оны жилийн эцсийн үзлэг шалгалтыг 2016 оны 5 дугаар сард явуулсан. Үзлэг шалгалтын явцад нийслэлийн хэмжээнд нийт 70 тэрбум 102.3 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж тухай бүр залруулуулсан.

Тус үзлэг, шалгалтын дүнг нийслэл болон 9 дүүргээр нийт 517 байгууллагын мэдээллийг нэгтгэн 2016 он 05 сарын 26-нд удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан бөгөөд хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд мэдээллүүдээ хугацаа хоцроож байршуулдаг нийтлэг зөрчил дутагдал байгаад зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

2015, 2016 ОНД ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ХАМРАХ ХҮРЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН АУДИТЫН ДҮН

Аудитын төрөл	Аудит хийсэн байгууллагын тоо		Зөрчлийн нийт дүн		Өгсөн зөвлөмж							
					Тоо		Төсөвт буцаан төвлөрүүлэх		Данс бүртгэлд тусгах, залруулах		Давтан гаргахгүй байх	
	2015 он	2016 он	2015 он	2016 он	2015 он	2016 он	2015 он	2016 он	2015 он	2016 он	2015 он	2016 он
Санхүүгийн аудит	21	11	17,787.2	7,653.2	71	54	0	4.5	1,281.8	10.9	16,505.4	7,637.8
Гүйцэтгэлийн аудит	21	21	12,312.2	3,537.1	320	209	28.3	12.5	1,623.5	806.2	10,660.4	2,718.4
Дүн	42	32	30,099.4	11,190.3	391	263	28.3	17.0	2,905.3	817.1	27,165.8	10,356.2